"ХЯМРАЛЫН ҮЕИЙН ЭРХ ЗҮЙ БА ХӨГЖИЛ" ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО 2

"МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЙЛБАР" НОМЫГ ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГ БОЛЛОО 4

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДАД "ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ" СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА 5



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

*Эрх чөлөөтэй байхын тулд хуульд захирагдах хэрэгтэй*
*Ж.Амарсанаа*

# Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn | Хууль зүйн мэдээ сонин | 2022.11.01


## ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ















## “ХЯМРАЛЫН ҮЕИЙН ЭРХ ЗҮЙ БА ХӨГЖИЛ” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО

Өнөөдөр Хууль зүйн үндэсний хүрээлэн байгуулагдсаны 20 жилийн түүхт ойн өдөр тохиож байна. Ойн арга хэмжээний хүрээнд “Хямралын үеийн эрх зүй ба хөгжил” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа. Хурлыг ХЗҮХ-ийн захирал Х.Эрдэм-Ундрах нээж, Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, УИХ-ын гишүүн, ХЗДХЯ-ны сайд Х.Нямбаатар, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгч, ноён Феликс Гленк, МУИС-ийн ХЗС-ийн захирал, Проф.Др Б.Амарсанаа нар мэндчилгээ дэвшүүлж үг хэлэв. Тус хуралд Академич, МУИС-ийн Эмирет профессор, ХЗҮХ-ийн эрдмийн зөвлөлийн дарга С.Нарангэрэл, ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Сингапурын Үндэсний их сургуулийн Хууль зүйн сургуулийн проф. Др. Эндрью Жеймс Хардинг, Европын компанийн засаглалын хүрээлэнгийн судлаач гишүүн Проф.Др. Дан В.Пучниак, Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан МУИС-ийн ХЗС-ийн ахлах багш Д.Ганзориг, Монгол Улсын гавьяат хуульч Проф. Др. Ж.Бямбаа, Япон Улсын Кобэгийн их сургуулийн Хууль зүйн ахисан түвшний сургуулийн Проф.Др Наруфуми Кадомацу, МУИС-ын ХЗС-ийн ахлах багш Др. Б.Буянхишиг, Проф. Др. Б.Уранцэцэг, БНСУ-ын Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэнгийн Тэрүүлэх судлаач Др.И Жун Со, Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэнгийн ахлах судлаач Др.Чой ЖИ Ён нар илтгэл хэлэлцүүллээ.





## ЯПОН УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХАРЬЯА СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНТЭЙ ХАМТАРЧ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн Япон улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр “Өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн процессын ажиллагаа ба эрүүгийн хариуцлагын тогтолцоо: Япон ба Монгол Улсын харьцуулалт” сэдвээр эрдэм шинжилгээний семинар зохион байгуулав.

Тус семинарт Сургалт, судалгааны хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны газрын профессор Минако Шожи “Япон улсын өсвөр насны хүнд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ба өсвөр насны хүнд оногдуулах хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ” сэдвээр, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор (Dr.jur) Х.Эрдэм-Ундрах “Монгол Улс дахь өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдвээр, МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш Х.Болормаа (LL.M) “Монгол Улс дахь өсвөр насны сэжигтэн яллагдагч, шүүгдэгчид холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүллээ.

Хэлэлцүүлэгт, талуудын төлөөлөл танхимаар оролцсоноос гадна Сургалт, судалгааны хүрээлэнгийн хамт олон, НҮБ-ын Ази, Алс Дорнодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээлэн (UNAFEI)-ийн албан хаагчид цахимаар оролцсон. Мөн Сургалт, судалгааны хүрээлэнгийн төлөөлөгчид ХЗҮХ-ийн үйл ажиллагаатай танилцаж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцов.



## “МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЙЛБАР” НОМЫГ ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГ БОЛЛОО

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг батлан гаргасан билээ.

Энэ хуулийн ажлыг хэсгийн гишүүд “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тайлбар” ном туурвиж, нийтийн хүртээл болголоо. Бүтээлийг танилцуулах өдөрлөг 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд боллоо.

Танилцуулах өдөрлөгийг нээж, Монгол Улсын Гавьяат хуульч, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (ScD), профессор Д.Лүндээжанцан, номын редактор Монгол Улсын С айд, Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

Номын зохиогч болох нэгжийн хуулийн дэд ажлын хэсгийн ахлагч Д.Ганзориг, Улсын Бага Хурал, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн нар тус номыг гаргах болсон үндэслэл, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн үзэл баримтлал, цаашид түүнийг дагаж мөрдөхөд өөрчлөгдөх асуудлуудыг хөндөж, санал солилцлоо.

Номын танилцуулах өдөрлөгт номын зохиогч, Монгол Улсын Гавьяат хуульч Н.Лувсанжав, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, доктор /PhD/ Х.Эрдэм-Ундрах, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор /PhD/ С.Сүхбаатар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатар, хууль зүйн их, дээд сургуулиудын төлөөлөл, хуульч, судлаачид зэрэг хүндэт зочид, төлөөлөгчид оролцлоо.






## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДАД “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр цуврал сургалт зохион байгуулдаг. Энэ удаад 25 дугаар тусгай сургуулийн ахлах ангийн 20 гаруй сурагчдыг хамрууллаа. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн арга зүйч багш Д.Цэцэгдарь, сургалт хариуцсан мэргэжилтэн П.Аззаяа нар хичээл заав.





## “ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛД БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА






## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ БЭЛТГЭХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)-аас Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” (2019-2023) төслийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар болон Монголын Хуульчдын Холбоотой хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэх нь” сэдвээр төвийн бүсийн мэргэжилтэн бэлтгэх сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 18, 19, 20, 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Тус сургалтад Архангай, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн 53 эрх зүйн хөтөч хамрагдлаа.

Сургалтыг “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ” гарын авлагад суурилан мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх төслийн хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш нар болон төслийн зөвлөхүүд удирдан явууллаа.

Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн арга зүйч багш Цэцэгдарь эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legal-info.mn, www.e-khutuch.mn цахим хуудасны талаар мэдээлэл өгч, Эрх зүйн хөтчийн сургалтын гарын авлага, “Малчин танд” гарын авлага, www.e-khutuch.mn цахим хуудасны танилцуулга, Хөдөлмөрийн тухай хуулийн нугалбар хуудас болон бусад сургалтын материалаар оролцогчдыг хангав.









Хууль зүйн мэдээ
Улсын бүртгэлийн дугаар 1197
Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу /15160/, Хуульчдын гудамж 1, Хууль зүйн үндэсний хүрээлэн.
11-315789
www.nli.gov.mn
Бэлтгэсэн Ц.Энхжин

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

*Иргэн танд хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл хэрэгтэй байна уу?*



# Иргэн ТА

**1800-1202**

ТУСГАЙ ДУГААРЫН УТСАНД ХОЛБОГДОЖ, ХУУЛЬ ЗҮЙН АНХАН ШАТНЫ ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЭЛ АВААРАЙ.

08:30-17:30 ЦАГИЙН ХООРОНД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛОМЖТОЙ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Эрх зүйн хөтчийн цахим сургалтын платформ
https://elearn.nli.gov.mn/

ИРГЭДИЙН ОРОЛЦОО ТӨСӨЛ




Эрх зүйн хөтчийн цахим сургалтын платформ https://elearn.nli.gov.mn/ цахим хуудсыг нээтрүүлээ.

Эрх зүйн хөтчийн цахим сургалтын https://elearn.nli.gov.mn/ цахим хуудас нь Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн хөтчийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэшсэн эрх зүйн хөтчийн тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх платформ юм.

*ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ИРГЭН БҮРД...*